



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/05

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.15, 59 дүгээр зүйлийн 59.2.1 дэх заалт, 2017 оны Төсвийн тухай хууль, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Хот тохижуулах газартай "Хот байгуулалт, тохижилтын ажил"-ыг аймгийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн суурь зарлага болох 117,554,000 / Нэг зуун арван долоон сая таван зуун тавин дөрвөн мянга/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Хот байгуулалт, тохижилтын ажлыг батлагдсан графикын дагуу чанартай гүйцэтгэхийг Хот тохижуулах газар /Д.Мөнхцоож/-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж, ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Санхүү төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

О.ЧУЛУУНБАТ

0301987